НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ГАЗАР

# ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ (ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР)

2025 оны 12 дугаар сарын 04 Улаанбаатар хот

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Хэрэгжилт) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Нэг. Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр | | | | | | |
| 1. | Байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулах | I улирал | Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөг батлуулсан байна | Ёс зүйн дэд хороо төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулсан байна | Ёс зүйн дэд хорооноос 2025 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, ёс зүйн дэд хорооны даргаар батлуулсан. Төлөвлөгөөнд 13 арга хэмжээг тусган ажиллаж байна. | 100% |
| 2. | Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах | I-IV улирал | Нөлөөллийн чиглэлээр өгсөн мэдээллийн тоо | Ёс зүйн зөрчлийн талаар мэдлэг ойлголтыг албан хаагчдад өгсөн байна. | Тайлант хугацаанд хууль, журмын талаар танилцуулга, мэдээллийг 2 удаа өгч ажилласан. Үүнд:<br>✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, төрийн албан хаагчийн ёс зүй болон бүх нийтийн ёс зүйн боловсролын талаарх контент, зурагт хуудсыг нийт албан хаагчдад НН3Б-ын дотоод удирдлагын цахим систем(UBERP) болон “НАЖГ дотоод групп” Viber бүлгээр мэдээлж албан хаагчдад түгээн хүргэж танилцуулсан. Албан хаагчдыг уншиж, судлах боломжийг бүрдүүлсэн.<br>✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт танилцуулгыг боловсруулж газрын албан хаагчдад танилцуулан, дотоод сүлжээнд байршуулсан.<br>✓ Байгууллагадаа Ёс зүйн мэдээллийн самбар шинээр хийж Ёс зүйн тухай хууль, журам, нөлөөллийн ажлыг хийж ажилласан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3. | Дэд хорооны хуралдааны тэмдэглэлийг тухай бүр хөтлөх | Тухай бүр | Тэмдэглэл хөтөлж, бүрэлдэхүүнд танилцуулан гарын үсэг зуруулсан байх. | Хуралдааны тэмдэглэлийг тухай бүр хөтөлж, албажуулсан байна. | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол ирээгүй тул дэд хороо хуралдаагүй болно. | 100% |
| 4. | Хамт олноос харилцаа хандлагын судалгаа авах | Жилдээ 1 удаа | Ёс зүйн хандлага, харилцааны талаар судалгаа авсан байна. | Ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлнэ | Байгууллагын албан хаагчдыг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх, албан хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор Ёс зүйн дэд хорооноос "Ажилтны ёс зүй, харилцаа хандлага"-ын судалгааг 13 асуулгын хүрээнд боловсруулж, Google forms программ ашиглан байгууллагын 18 албан хаагч хамрагдаж, өөрсдийн тулгамдаж буй хэрэгцээний талаар санал асуулгад хариулт өгсөн байна. Судалгааны үр дүнг нийт албан хаагчдад танилцуулсан. Уг судалгаагаар албан хаагчид харилцаа хандлага, байгууллагын соёл гэсэн чиглэлээр сургалтад хамрагдах хүсэлтэй байсан тул энэ чиглэлийн сургалт, нөлөөллийн чиглэлийн арга хэмжээнүүдийг III-IV улиралд төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажилласан. | 100% |
| 5. | Албан хаагчдыг ёс зүйн сургалтад хамруулах | III-IV улирал | 1-ээс доошгүй удаа сургалтад хамруулсан байх, хамрагдсан албан хаагчийн тоо | Албан хаагчдад ёс зүйн талаар мэдлэг олгох сургалтад хамруулсан байна. | Тайлант хугацаанд танхимын 1, цахим 2 удаагийн сургалтад 13 албан хаагчийг хамруулсан.<br>Үүнд:<br>✓ Байгууллагын хамт олны харилцаа хандлагыг сайжруулах чиглэлээр 2025.06.04-ний 9 цагт Нийслэлийн хүний хөгжлийн төвтэй хамтран танхимаар "Төрийн албан хаагчийн ёс зүйн харилцааны соёл" сэдэвт сургалтад 10 албан хаагч;<br>✓ Төрийн албаны зөвлөлийн "7:4:10" хөтөлбөрийн хүрээнд Төрийн албаны төв зөвлөлөөс зохион байгуулж буй сургалтад байгууллагын албан хаагчид цахим сургалтад | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдан мэдлэг, чадвараа нэмэгдүүлэн ажиллаж байна. | |
| Хоёр. Гомдол мэдээллийн ёс зүйн зөрчлийн судалгаа, хянан шалгах чиглэлээр | | | | | | |
| 6. | Байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах | Тухай бүр | Ирсэн гомдлын тоо, Шийдвэрлэсэн гомдлын тоо | Ирсэн гомдлыг хянан үзэж, шийдвэр гаргаж, хариу өгсөн байна. | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол ирээгүй байна. | 100% |
| 7. | Байгууллагад гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл, эрсдэлийг тооцох | Жилдээ 1 удаа | Дүн шинжилгээ хийсэн байх | Төрийн албаны зөвлөл, ёс зүйн хороо, Хүний эрхийн үндэсний комисс, Авлигатай тэмцэх газар, мэргэжлийн холбоо, салбарын удирдах эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмж, албан даалгавар, судалгаа, өмнөх жилийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ, тайлан зэргийг харгалзан үзэж, эрсдэлийг тодорхойлон дүн шинжилгээ хийсэн байна. | Байгууллагад үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил байгаа эсэх талаар түүврийн аргаар 6 албан хаагчтай биечлэн ярилцлага хийж, дэд хорооны гишүүд дүн шинжилгээ хийж шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцож ажилласан. Байгууллагад үүсч болзошгүй ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, харилцаа хандлагын сэдвээр сургалт оруулах, нөлөөллийн ажлуудыг хийх, зөвлөмж хүргүүлэх ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | 90% |
| 8. | "Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх | I-IV улирал | Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байх | "Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | "Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ыг хэрэгжүүлэн ажиллаж 2025 оны хагас жилийн тайлан гарган НЗДТГ-т хүргүүлсэн. | 90% |
| 9. | Ёс зүйн хариуцлага тооцсон шийдвэрийг "Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэх | Тухай бүр | Системд мэдээллийг оруулсан байх | Цахим системд мэдээллийг оруулж, мэдээллийн сан бүрдүүлж, нэмэлт, өөрчлөлтийг тухай хийсэн байна. | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой хариуцлага тооцсон шийдвэр гараагүй | 100% |
| Гурав.Үйл ажиллагааны тайлан, мэдээ тайлагнах чиглэлээр | | | | | | |
| 10. | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээ гаргаж, Ёс зүйн хороонд хүргүүлэх | Мэдээ улирал бүр, Тайланг | Хугацаанд нь хүргүүлсэн байх | Төрийн албан хаагчид хүлээлгэсэн шийдвэрийг холбогдох мэдээллийн хамт улирал бүр, үйл ажиллагааны тайланг дараа | Тус газрын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн, 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | дараа оны 1 дүгээр сар | | оны 01 дүгээр сард багтаан Ёс зүйн хороонд тайлагнасан байна. | мэдээллийг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан бичгээр хүргүүлэн ажилласан. | |
| 11. | Ёс зүйн дэд хорооны холбогдох баримтыг архивд шилжүүлэх | 2025 оны 01 дүгээр сар | 2024 онд үүссэн баримтыг архивд шилжүүлсэн байх | Бүрэн бүрдэлтэй архивын хадгаламжийн нэгж үүсгэн архивд шилжүүлсэн байна. | Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтаар цаасан суурьт 1 хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивт акт бүртгэлийн дагуу хугацаанд нь хүлээлгэн өгсөн.<br>2025 онд үүсч буй баримтыг албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, стандартын дагуу хөтлөн ажиллаж байна. | 90% |
| Дөрөв. Үйл ажиллагааны ил тод байдлыг хэрэгжүүлэн ажиллах чиглэлээр | | | | | | |
| 12. | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил шийдвэрлэлтийн талаар олон нийтэд мэдээлэх | Тухай бүр | Олон нийтэд мэдээлсэн байх | Төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй бол энэ талаарх мэдээллийг болон нийтэд заавал мэдээллэх хуулийн заалт хангагдана. | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол гараагүй. | 100% |
| 13. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг байгууллагын цахим хуудаст байршуулан олон нийтэд мэдээлэх | 2026 оны 01 дүгээр сар | Олон нийтэд мэдээлсэн байх | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 19.1 дэх заалт хангагдсан байна. | 2024 оны тайланг байгууллагын цахим хуудаст байршуулсан. 2025 оны тайланг 2026 оны 01 дүгээр сард багтаан тайлагнана. | 90% |
| Дундаж гүйцэтгэлийн хувь: 96% | | | | | | |

Танилцсан:
ГАЗРЫН ДАРГА Д.БАТСҮХ

Тайлан гаргасан:
ДАРГА Б.ЦОЛМОНГЭРЭЛ
НАРИЙН БИЧИГ Ч.ЭНХ-ОТГОН